



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/125/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Булган хот 2022 он	Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn Аудитор: Б.Пүрэвсүрэн Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан	12
3.1 Ерөнхий зүйл	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	16
3.8 Аудитын гол асуудал	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХАА	Хөдөө аж ахуй

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.24 № 28
танай _____ ны № _____ т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Н.БАТЖАРГАЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:/bichighereg/2022A4toot

006020007

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	1,381,803,568.00	1,176,073,691.90
33	АВЛАГА	1,381,803,568.00	1,176,073,691.90
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	1,352,799,044.00	1,147,259,167.90
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	429,550,134.00	418,939,934.00
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	116,374,910.00	110,267,660.00
33706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	496,100,000.00	373,450,574.00
33720	Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл	46,500,500.00	10,110,500.00
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	47,213,500.00	58,352,499.90
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	217,060,000.00	176,138,000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	190,000.00	-
33500	Бусад авлага	28,814,524.00	28,814,524.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	28,814,524.00	28,814,524.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	(0.00)
35400	Хангамжийн материал	-	(0.00)
35440	Түлш, шатах тослох материал	-	(0.00)
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1,381,803,568.00	1,176,073,691.90
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	79,707,250.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	79,707,250.00	-
41700	Хөтөлбөртэй холбоотой өглөг	79,707,250.00	-
41703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих хөтөлбөр	7,680,000.00	-
41706	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	40,000,000.00	-
41716	Нийтийг хамарсан ажил	6,472,200.00	-
41717	Ахмад мэргэжилтний зөвлөг үйлчилгээ	11,200,000.00	-
41722	Зохион байгуулалттай байр бий болгох зорилтот төслийн санхүүжилт	1,000,000.00	-
41723	Гэрээт малчин төслийн санхүүжилт	13,075,050.00	-
41728	Хүүхэд хамгаалагч төсөлтэй холбоотой өглөг	280,000.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1,302,096,318.00	1,176,073,691.90
51	Засгийн газрын хувь оролцоо	1,302,096,318.00	1,176,073,691.90
51200	Хуримтлагдсан үр дүн	1,302,096,318.00	1,176,073,691.90
51210	Өмнөх үеийн үр дүн	1,191,899,348.00	1,301,906,318.00
51220	Тайлант үеийн үр дүн	110,196,970.00	(125,832,626.10)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1,381,803,568.00	1,176,073,691.90

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	571,249,220.00	590,845,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,166,720.00	7,200.00
1200	Өмчийн орлого	5,166,720.00	7,200.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,166,720.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	5,166,720.00	-
120009	Бусад орлого /Үнэ төлбөргүй/	-	7,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	566,082,500.00	590,838,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	256,134,500.00	590,838,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,134,500.00	15,195,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	251,000,000.00	575,643,400.00
1350	Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	309,948,000.00	-
13503	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	309,948,000.00	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	461,052,250.00	716,678,226.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	461,052,250.00	716,678,226.10
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,694,800.00	5,119,125.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,998,800.00	3,962,125.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,998,800.00	3,700,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	262,125.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	696,000.00	1,157,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	696,000.00	1,157,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	458,357,450.00	711,559,101.11
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,433,780.00	848,150.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,425,920.00	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,860.00	848,150.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,399,000.00	13,775,875.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,500.00	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	13,386,500.00	13,775,875.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	223,336,580.00	509,295,092.10
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	223,336,580.00	509,295,092.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	216,188,090.00	187,639,984.01
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	216,188,090.00	187,639,984.01
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	110,196,970.00	(125,832,626.10)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	110,196,970.00	(125,832,626.10)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Бусад	НИЙТ ДҮН
1	ҮЛДЭГДЭЛ	-	1,191,899,348.00		1,191,899,348.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-

3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	110,196,970.00	-	110,196,970.00
8	ҮЛДЭГДЭЛ	-	1,302,096,318.00	-	1,302,096,318.00
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(190,000.00)	-	(190,000.00)
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	1,301,906,318.00	-	1,301,906,318.00
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	(125,832,626.10)	-	(125,832,626.10)
16	ҮЛДЭГДЭЛ	-	1,176,073,691.90	-	1,176,073,691.90

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	793,097,500.00	590,845,600.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	227,015,000.00	7,200.00
1200	Өмчийн орлого	227,015,000.00	7,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	227,015,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	221,589,080.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	5,425,920.00	-
120009	Бусад орлого /Үнэ төлбөргүй/	-	7,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	566,082,500.00	590,838,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	256,134,500.00	590,838,400.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,134,500.00	15,195,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	251,000,000.00	575,643,400.00
1350	Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	309,948,000.00	-
13503	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	309,948,000.00	-
14	ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	465,539,876.10
145	Бусад орлого (олз)	-	465,539,876.10
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	793,097,500.00	1,056,385,476.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	793,097,500.00	1,056,385,476.10
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,694,800.00	5,119,125.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,998,800.00	3,962,125.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,998,800.00	3,700,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	262,125.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	696,000.00	1,157,000.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	696,000.00	1,157,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	790,402,700.00	1,051,266,351.10
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,433,780.00	848,150.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,425,920.00	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	7,860.00	848,150.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	13,399,000.00	13,775,875.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,500.00	-
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	13,386,500.00	13,775,875.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	221,589,080.00	509,295,192.10
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	221,589,080.00	509,295,192.10
2132	Бусад урсгал шилжүүлэг	549,980,840.00	527,347,134.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	549,980,840.00	527,347,134.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	-	(465,539,876.10)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	-	-
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	465,539,876.10
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	-	465,539,876.10
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	465,539,876.10
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	-	-
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
10	Оны эхний үлдэгдэл	-	-	-
101	Харилцахын эхний үлдэгдэл	-	-	-
102	Кассын эхний үлдэгдэл	-	-	-
11	ОРЛОГЫН НИЙТ ДҮН	584,643,400.00	1,042,609,601.10	(457,966,201.10)
112	ХЭД сангаас хуваарилсан санхүүжилт	503,436,150.00	575,643,400.00	(72,207,250.00)
1121	Үндсэн санхүүжилт	503,436,150.00	495,936,150.00	7,500,000.00

1122	Өмнөх оны өр барагдуулах санхүүжилт	-	79,707,250.00	(79,707,250.00)
113	Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламж	-	1,419,125.00	(1,419,125.00)
115	ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого	1,500,000.00	-	1,500,000.00
118	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт	-	465,539,876.10	(465,539,876.10)
120	Нэр данс зөрүү орлого	-	7,200.00	(7,200.00)
122	Өмнөх оны үлдэгдэл	79,707,250.00	-	79,707,250.00
2	ЗАРЦУУЛАЛТЫН ДҮН	583,143,450.00	1,042,609,601.10	(459,466,151.10)
21	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээ хангах үйлчилгээ	7,200,000.00	7,190,000.00	10,000.00
211	Ганцаарчилсан	7,200,000.00	7,190,000.00	10,000.00
2111	Ажил мэргэжлээ сонгох, үйлчилгээ авах тухай зөвлөгөө өгөх /ганцаарчилсан/	7,200,000.00	7,190,000.00	10,000.00
22	Ажилд зуучлах үйлчилгээ	4,480,000.00	4,464,600.00	15,400.00
222	Ажилд зуучлах үйлчилгээ	4,480,000.00	4,464,600.00	15,400.00
23	Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр	11,426,000.00	5,526,000.00	5,900,000.00
231	Хөдөлмөрт бэлтгэх арга хэмжээ	3,236,000.00	1,386,000.00	1,850,000.00
2311	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө мэдээлэл өгөх	276,000.00	276,000.00	-
2312	Ажлын байрны харилцаа, сэтгэл зүйн сургалт зохион байгуулах	1,110,000.00	1,110,000.00	-
2313	Ажлын байранд зуучлах уулзалтанд бэлтгэх	1,850,000.00	-	1,850,000.00
232	Хөдөлмөр эрхлэлтийн сургалтанд хамруулах	8,190,000.00	4,140,000.00	4,050,000.00
2322	Танхимын сургалт зохион байгуулах	4,140,000.00	4,140,000.00	-
2323	Хоол унааны зардал	4,050,000.00	-	4,050,000.00
24	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр	203,100,000.00	200,190,050.00	2,909,950.00
241	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	120,000,000.00	120,000,000.00	-
242	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт явуулах	3,000,000.00	3,000,000.00	-
2421	Санхүү, нягтлан бодох бүртгэлийн сургалт явуулах	3,000,000.00	3,000,000.00	-
243	Борлуулалтын дэмжлэг	10,100,000.00	7,200,000.00	2,900,000.00
2460	Нийтийг хамарсан ажил	70,000,000.00	69,990,050.00	9,950.00
25	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр	18,350,000.00	18,000,000.00	350,000.00
252	Шилдэг Старт-Ап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох	18,000,000.00	18,000,000.00	-
2522	Шилдэг Старт-Ап залуу, залуучуудын багийг сонгон шалгаруулах	10,000,000.00	10,000,000.00	-
2523	Старт-Ап залуучуудад ментор хийх	8,000,000.00	8,000,000.00	-

254	Засгийн газрын 2020 оны 228 дугаар тогтоолоор батлагдсан Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмын хэрэгжилтийг хангах, цагийн ажилд зуучлах	350,000.00	-	350,000.00
26	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр	84,800,000.00	81,229,140.00	3,570,860.00
261	Малчин өрхийг малжуулах /100 хувь эргэн төлөгдөх/	80,000,000.00	79,000,000.00	1,000,000.00
262	Мал аж ахуй эрхлэлтийн сургалт, туршлага солилцох уулзалт	4,800,000.00	2,229,140.00	2,570,860.00
27	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр	81,790,000.00	66,700,000.00	15,090,000.00
270	Хөдөлмөрт бэлгэх арга хэмжээ	10,000,000.00	1,540,000.00	8,460,000.00
2701	Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох /ХБИ/	10,000,000.00	1,540,000.00	8,460,000.00
271	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих арга хэмжээ	57,000,000.00	57,000,000.00	-
2711	Дэмжлэгтэйгээр ажилд зуучлах үйлчилгээ	-	-	-
2712	Иргэнд үзүүлэх санхүүгийн дэмжлэг /50 хувь эргэн төлөгдөх/	56,000,000.00	56,000,000.00	-
2714	Ажил олгогчид олгох санхүүгийн дэмжлэг /эргэн төлөлттэй/	-	-	-
2716	Аж ахуй эрхлэлтийн ур чадвар олгох сургалт	1,000,000.00	1,000,000.00	-
272	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ	5,040,000.00	-	5,040,000.00
2721	Ажил олгогчийн урамшуулал	5,040,000.00	-	5,040,000.00
273	ХБИ Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	7,350,000.00	5,820,000.00	1,530,000.00
2731	Ажлын байрны түрээсийн хөнгөлөлт	7,350,000.00	5,820,000.00	1,530,000.00
274	Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохин байгуулах	2,400,000.00	2,340,000.00	60,000.00
2741	Танхимын сургалт зохион байгуулах	2,400,000.00	2,340,000.00	60,000.00
28	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр	43,920,000.00	40,945,000.00	2,975,000.00
281	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	10,920,000.00	7,945,000.00	2,975,000.00
282	Санхүүгийн дэмжлэг /100 хувь эргэн төлөгдөх/	33,000,000.00	33,000,000.00	-
30	Хүүгийн хөнгөлөлт	700,000.00	-	700,000.00
301	Хүүгийн хөнгөлөлт	700,000.00	-	700,000.00
32	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл	4,548,200.00	3,700,000.00	848,200.00
321	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл	4,548,200.00	3,700,000.00	848,200.00
33	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилт	750,000.00	745,000.00	5,000.00
331	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилт	750,000.00	745,000.00	5,000.00
34	Бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах	1,420,000.00	1,420,000.00	-

341	Мэдээлэл цуглуулах	1,420,000.00	1,420,000.00	-
35	Хөдөлмөрийн салбарын ажилтнууд, ХНЗ-ийн 3-н талт хорооны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийгдэх чадавх бэхжүүлэх сургалт	8,000,000.00	7,623,660.00	376,340.00
351	Сургалт зөвлөлгөөн /хэлтсийн өөрийн/	8,000,000.00	7,623,660.00	376,340.00
36	Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах	6,000,000.00	2,246,979.00	3,753,021.00
361	Сурталчилгаа зохион байгуулах	6,000,000.00	2,246,979.00	3,753,021.00
37	Хөтөлбөр төслийн хяналт үнэлгээ	7,000,000.00	6,999,955.00	45.00
373	Хөтөлбөр төслийн хяналт үнэлгээ	7,000,000.00	6,999,955.00	45.00
39	Гарын авлага хэвлэмэл материал	2,600,000.00	2,597,200.00	2,800.00
391	Гарын авлага хэвлэмэл материал хэвлэх, олшруулах	2,600,000.00	2,597,200.00	2,800.00
40	Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр төслийн санхүүжилт	-	1,762,400.00	(1,762,400.00)
405	Хүүхэд хамгаалагч төсөл	2,352,000.00	1,762,400.00	589,600.00
41	ХЭЗҮ-ийн шийдвэрээр тодорхойлсон бусад хөтөлбөр, төслийн санхүүжилт	15,000,000.00	-	15,000,000.00
50	Хөдөлмөрийн зах зээлийг дэмжих туршилтын хөтөлбөр	-	1,419,125.00	(1,419,125.00)
502	Бичил бизнес эрхлэгчдийг дэмжих санхүүгийн бус дэмжлэг	-	1,157,000.00	(1,157,000.00)
50201	Зээлийн өмнөх сургалт	-	324,000.00	(324,000.00)
50202	Зээлийн дараах санхүүгийн бус үйлчилгээ	-	833,000.00	(833,000.00)
503	Орон нутгийн санаачилгын төсөл	-	262,125.00	(262,125.00)
50302	Хяналт шинжилгээний үнэлгээний зардал	-	262,125.00	(262,125.00)
602	2020 онд үүссэн өр барагдуулах	79,707,250.00	79,707,150.00	100.00
6024	Ажлын байрыг дэмжих хөтөлбөр / өглөг /	15,152,200.00	15,152,200.00	-
60245	Ажил олгогчийг дэмжих арга хэмжээ / өглөг /	7,680,000.00	7,680,000.00	-
602460	Нийтийг хамарсан ажил / өглөг /	6,472,200.00	6,472,200.00	-
602461	Зохион байгуулалттай ажлын байрыг дэмжих арга хэмжээ / өглөг /	1,000,000.00	1,000,000.00	-
6026	Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр / өглөг /	53,075,050.00	53,074,950.00	100.00
60261	Малчин өрхийг малжуулах /100 хувь эргэн төлөгдөх/ / өглөг /	40,000,000.00	40,000,000.00	-
60263	Гэрээт малчин өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ / өглөг /	13,075,050.00	13,074,950.00	-
6028	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр / өглөг /	11,200,000.00	11,200,000.00	-
60281	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ / өглөг /	11,200,000.00	11,200,000.00	-

6040	Засгийн газар, Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр төслийн санхүүжилт / өглөг /	280,000.00	280,000.00	-
60405	Хүүхэд хамгаалагч төсөл / өглөг /	280,000.00	280,000.00	
61	Төвлөрүүлэлт	-	510,143,342.10	(510,143,342.10)
6110	Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт - Төв сан	-	465,539,876.10	(465,539,876.10)
6130	Санхүүжилтын буцаалт - Төв сан	-	44,603,466.00	(44,603,466.00)
9	Эцсийн үлдэгдэл	-	-	-
91	Харилцахын эцсийн үлдэгдэл	-	-	-
92	Кассын эцсийн үлдэгдэл	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	-
	Татварын бус орлого	-	7,200.00
	Нийтлэг татварын бус орлого	-	7,200.00
1200042	Төсөвт байгууллагын өөрийн орлого /Туслах/	-	7,200.00
72102	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	-	577,069,725.00
80110	Гадаад зээл, тусламжийн ТЕЗ-д шилжих ажил үйлчилгээ	-	1,419,125.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,419,125.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,419,125.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,419,125.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	-	262,125.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	262,125.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,157,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,157,000.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,419,125.00
30	Нэр данс, зөрүү, төсөл хөтөлбөрийн орлого	-	(13,775,875.00)
300008	Гадаад орон, олон улсын байгууллага дээд шатны төсвийн захирагчаас олгосон санхүүжилтын зарцуулаагүй үлдэгдэл	-	(13,775,875.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	15,195,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан	-	15,195,000.00
80224	Зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс	-	4,548,150.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	4,548,150.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	3,700,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	3,700,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	-	3,700,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,700,000.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	848,150.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	848,150.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	4,548,150.00

1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	4,548,150.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	-	4,548,150.00
82616	ЗГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөтөлбөр, төсөл	-	571,102,450.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	571,102,450.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	527,347,134.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	527,347,134.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	527,347,134.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	527,347,134.00
26	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	43,755,316.00
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	43,755,316.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	571,095,250.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	571,095,250.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	-	571,095,250.00
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 01/44 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Нийгмийн халамжийн үйл ажиллагааны чанарыг сайжруулах, үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг зорилтот бүлэг, хүн амд оновчтой хүргэх замаар иргэдийг ажилтай орлогтой болгох, ажилгүйдэл ядуурлыг

бууруулах, Монгол хүний амьдрлын чанарыг сайжруулахад Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан эрхэм зорилго оршино.

Зорилтот бүлгийн өрхийн амьжиргааг дэмжих, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн цогц үйлчилгээгээр үйлчлүүлэгчдийнхээ амьдралд тохирсон нийгмийн эрсдлийг зөөлрүүлсэн, үйлчлүүлэгч төвтэй, мэргэшсэн чадварлаг ёс зүйг дээдэлсэн манлайлагч байгууллага болно.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чиг үүрэг

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санг байгуулна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах хяналт тавих үйл ажиллагаанд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн заасан журмын дагуу мөрдөж ажиллана.

Хүн амын хөдөлмөрлөх эрхийг хангах боломж, нөхцөлийг бүрдүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг тэнцвэржүүлэх замаар зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, ядуурлын түвшинг бууруулах

- Үндэсний хөдөлмөр эрхлэлт, халамжийн үйлчилгээний бодлогын хэрэгжилтийг дэлхийн жишигт хүргэн хөгжүүлэх

- Төрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, тэгш шударга, чанартай хүргэх чадварыг байнга дээшлүүлсэн суралцагч байгууллагыг хөгжүүлэх, стратегийн төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын чадамжийг дээшлүүлэх

ХЭҮЗ-ийн шийдвэрээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг дараах чиглэлээр үйл ажилагааг хэрэгжүүлнэ.

1. Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох хөтөлбөр
2. Ажлын байрыг дэмжих хөтөлбөр
3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр
4. Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр
6. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр
7. Орон нутаг, нийслэлийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн төсөл (Итгэлийн зээл)

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг дор дурдсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зарцуулна:

- ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;
- ажилд зуучлах; - хөдөлмөрт бэлтгэх;
- хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах;
- ажил олгогчийг дэмжих; - нийтийг хамарсан ажил зохион байгуулах;
- малчин, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих;

- ажил олоход хүндрэлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих;
- хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан, хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн сүлжээг бүрдүүлэх, ажиллуулах, шинэчлэх;
- хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийн үндэсний болон салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих, хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн эрхийн хэрэгжилтийг хянах, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа, сурталчилгаа явуулах, гарын авлага, хэвлэмэл материал бэлтгэж хэвлүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны үр дүнд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлгэх; - хууль тогтоомжид заасан, түүнчлэн Засгийн газрын болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн шийдвэрээр тодорхойлсон бусад хөтөлбөр, төслийг санхүүжүүлэх.
- мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих зориулалтаар мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих санд хөрөнгө хуваарилах.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 465,539,8 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4 653.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3 258,7 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх мөнгө түүнтэй адилтгах хөрөнгөнд төрийн сангийн данс, ХААН банкны данс, төрийн банкны данс гэсэн 3 харилцах данс ашигладаг байна.

Нийт хөрөнгийн хэмжээ тайлангийн хугацаанд 205,729.9 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь авлагын дүн буурсантай холбоотой.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	1,381,803.5	1,176,073,6	(205,729.9)
Бараа материал	00,00	00.0	00.00
Үндсэн хөрөнгө	00.00	00.00	00.00
Нийт хөрөнгө	1,381,803.5	1,176,073,6	(205,729.9)
Өр төлбөр	79,707,2	00.0	(79,707.0)
Хуримтлагдсан үр дүн	1,301,096.3	1,176,073,6	(125,832.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,381,803.5	1,176,073,6	(205,729.9)

2020 оны үлдэгдэл 1,381,803,5 мянган төгрөгийн авлаганаас тайлангийн хугацаанд 465,539,7 мянган төгрөгийн авлагыг барагдуулж нийт 260,000,0 төгрөгийн авлага үүсгэсэн болно. Тайлангийн хугацаанд ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 120,000.0 мянган төгрөгийн авлага үүсч 130.872,2 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан, малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 79,000.0 мянган төгрөгийн авлага үүсч 201,649,2 мянган төгрөгийн авлага барагдуулсан, залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрт авлага үүсгээгүй, 40,922,0 мянган төгрөгийг барагдуулсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт авлага үүсгээгүй 34,107,2 мянган төгрөгийн авлага барагдуулсан, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрт 33,000.0 мянган төгрөгийн авлага үүсч 21,861,0 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан, орон нутгийн онцлог төсөл хөтөлбөрт авлага үүсээгүй 36,390,0 мянган төгрөгийн авлага тус тус барагдуулсан байна.

Санхүүгийн тайлангийн бусад авлагат бүртгэгдсэн 28,214.5 мянган төгрөгийн авлага нь олон жилийн өмнө үүссэн хувь хүнээс авах авлага байна.

2021 онд шинээр өглөг нэмж үүсгээгүй, 2020 оны 79,707.2 мянган төгрөгний өглөгийг тайлант жилд дээд шатны байгууллагаас өр барагдуулах санхүүжилт ирснээр уг өглөгийг ходбогдох ААН, иргэнд олгож барагдуулсан.

Булган аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 19,596.3 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн, нийт зардал өмнөх оноос 255,625.9 мянган төгрөгөөр буюу 55.4 хувиар өссөн байна. Энэ нь буцаан төлөгдөж буй зээлийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагаас хүргүүлсэн 598,338.4 мянган төгрөгийн төсвийн төслийг 7,000.0 мянган төгрөгөөр бууруулан 590,838.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Нийт 1,056,378,2 мянган төгрөгний орлогоноос 532,458,9 мянган төгрөгийн зардал гарч гүйцэтгэл нь 92,1%-тай байна. Үүнээс 2021 оны санхүүжилтээс 44,603.4 мянган төгрөг, зээлийн эргэн төлөлтийн орлого 465,539,8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэлийг харуулбал АМЧБОлгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээ: 7,190.0 мянган төгрөг, ажилд зуучлах 4,464.6 мянган төгрөг, хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт 5,526,0 мянган төгрөг, цар тахлыг үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрт 281,419.1 мянган төгрөг, залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 18,000.0 мянган төгрөг, ХБИ-ний ажлын байрыг дэмжих хөтөлбөр 66,700.0 мянган төгрөг, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ хөтөлбөрт 40,945.0 мянган төгрөг, ЗГ, Хөдөлмөх эрхлэлтийн үндэсний зөвлөл, бусад хөтөлбөр төслийн санхүүжилт 1,762,4 мянган төгрөг, хөдөлмөрийн салбарын ажилтнуудын сургалт 7,623.6 мянган төгрөг, бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах 1,420,0 мянган төгрөг, ХЭ-н үндэсний зөвлөл 3,700,0 мянган төгрөг, хөдөлмөрийн харилцаа үндсэн эрхийн хэрэгжилт 745,0 мянган төгрөг, хөтөлбөр, төслийн хяналт үнэлгээ 6,999.5 мянган төгрөг, гарын авлага хэвлэмэл материал 2,597,2 мянган төгрөгийн зардал тус тус гарсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. 2021 онд нэмэлт төсвийн санхүүжилт байхгүй болно.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олгосон зээлээс тайлангийн хугацааны эцэст 19 иргэний 20 116.0 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн байна. Шатахууны гэрээний дагуу олгодог шатахууны урамшууллыг орлогод авч бүртгэлд тусгаагүй байна. Салбар зөвлөлийн гишүүдийн урамшуул олгосон цалингаас нийгмийн даатгалын шимтгэл тооцдоггүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд жилийн эцсийн байдлаар мэдээлбэл зохих 119 мэдээллийг бүрэн оруулсан. Хугацаа хоцроосон болон оруулаагүй мэдээлэл байхгүй. Мэдээллүүдийг заасан хугацаанд үнэн зөв гаргаж, цахим систем болон байгууллагын шилэн дансны самбарт цаасан хэлбэрээр гарган тогтмол байршуулан иргэд болон олон нийтийг мэдээллийн ил тод байдлаар хангаж ажилласан.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 79,000.0 мянган төгрөгийн өглөгийг барагдуулах 1 зөвлөмжийн хэрэгжилтийг 100 хувьтай хангуулсан байна.

Хүснэгт. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	хувь
Акт	-	-	-	-	-	-	
Албан шаардлага					-	-	
Зөвлөмж	1	79,000.0	1	79,000.0	-	-	
Нийт дүн	1	79,000.0	1	79,000.0	-	-	

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар хугацаа хэтэрсэн зээлийн барагдуулалт болон бусад авлагыг барагдуулах талдээр арга хэмжээ авч ажиллаж байгаа эсэхийг шалгах аас бусад чухал асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 20 116.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч 2 зөвлөмж өгсөн байна.

4.1 Залруулсан алдаа

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитад залруулсан алдаа байхгүй. Шатахууны урамшууллыг орлогод авч бүртгэлд тусгаж байх.

4.2 Албан шаардлага

Албан шаардлага хүргүүлэх хэмжээний алдаа зөрчил гаргаагүй болно.

4.3 Акт

Тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар гаргасан алдаа зөрчилд акт хүргүүлээгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас олгосон зээлээс тайлангийн хугацааны эцэст 19 иргэний 20 116.0 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн байна. Энэ нь Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-ын заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2016 оны 276 дугаар тогтоолоор батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох, түүнд батлан даалт гаргах, түүнд батлан даалт гаргах, хүүг нөхөн төлөх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам"-д заагдсан хугацаагаар зээлийг олгож хугацаа хэтрүүлэхгүй байх.

2. Бараа материалын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу шаардах хуудас, орлого зарлагын баримтны тамга тэмдэгээр баталгаажаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" заалтад нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Иж бүрэн тамга тэмдэг, гарын үсгээр баталгаажсан анхан шатны баримтаар гүйлгээг хийж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	ХЭДС	2	20,116.0							2	20,116.0


Дүн	2	20,116.0							2	20,116.0
-----	---	----------	--	--	--	--	--	--	---	----------

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

"БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН


АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ:



Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:



Ж.ЭНХЦОДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Д.АНХБАЯР